



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 9 сарын 15 өдөр

Дугаар 20

Зуунмод

Газар олголт, өмчлүүлэлтийн ажлыг
шалгасан дүнгийн тухай

Аж ахуйн нэгж, иргэн, байгууллагад газар эзэмшүүлэлт, иргэдэд газар өмчлүүлэлтийн талаар хийж буй ажил, үр дүнгийн байдлыг шалгаж, судалгаа дүгнэлт хийсэн тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч, Ажлын хэсгийн ахлагч Ц.Дашдэмбэрэлийн мэдээллийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар тогтоолоор томилогдсон Ажлын хэсэг Алтанбулаг, Баян, Баянчандмань, Заамар, Сэргэлэн сумд, аймгийн Газрын харилцаа, хот байгуулалтын газарт аж ахуйн нэгж, иргэн, байгууллагад газар эзэмшүүлэлт, иргэдэд газар өмчлүүлэлтийн талаар хийж буй ажил, үр дүнгийн байдлыг шалган танилцаж, зохих судалгаа дүгнэлт хийсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүр Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор тухайн жилд хийх ажлын чиглэлийг баталж, түүнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг тусган батлаж, хэрэгжилтийг хангуулан, үр дүнг хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгч, зохих шийдвэр гаргажээ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар зохион байгуулж, хийсэн ажлын тайланг Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж байсан байна.

Аймгийн газрын нэгдмэл сангийн тайлангаас үзэхэд иргэн, аж ахуйн нэгжид 2013 онд 10.3 мян.га, 2014 онд 26.1 мян.га, 2015 онд 13.5 мян.га газрыг тус тус эзэмшүүлснээс 2013 онд 1231 га буюу 12 хувийг, 2014 онд 771.2 га буюу 2.9 хувийг, 2015 онд 2494.4 га буюу 18.5 хувийг нь дуудлага худалдаагаар эзэмшүүлжээ.

0100020

My doc: Togtool 2016-3 ulral.

Монгол улсын Засгийн газраас жил бүр батлагдсан иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлын дагуу газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулж, 2013 онд 4413 иргэнд 524.4 га, 2014 онд 3968 иргэнд 705.7 га, 2015 онд 5861 иргэнд 1022.1 га, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 1507 иргэнд 202.2 га газрыг тус тус өмчлүүлсэн бөгөөд өссөн дүнгээр аймгийн иргэдийн 38.7 хувь буюу 34804 нь газар өмчилж авсан байна.

Ажлын хэсгийн шалгалтын ажлын дүнгээс үзэхэд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх ажилд зарим алдаа, дутагдал гарсан байна.

Газрын тухай хуулийн 29.1, 29.2, 29.3 дахь заалтаас өөр зориулалт, илүү хэмжээгээр газар эзэмшүүлэх, ашиглуулахдаа дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгох журмыг чанд мөрдөж ажиллах зорилт бүрэн хэрэгжиж чадаагүй байна. Жишээлбэл, Баян сумын Засаг дарга сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 500 га газрыг “Баянсаминтал” ХХК-д эрх хэмжээгээ хэтрүүлэн, дуудлага худалдаа явуулалгүйгээр тариалангийн зориулалтаар эзэмшүүлжээ.

Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газрыг эзэмшүүлэх, өмчлүүлэх дутагдал гарсан байна. Аймгийн Засаг даргаар ажиллаж байсан Д.Баярбат Зуунмод сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зарим газрыг эрх мэдлээ ашиглан, дуудлага худалдаа явуулалгүйгээр эзэмшүүлэх шийдвэр гаргасан байна.

Заамар сумын Засаг дарга, газрын даамал, байгаль орчны байцаагч нарын хариуцлагагүй ажиллагаанаас хамааран олон аж ахуйн нэгж газар эзэмших захирамжгүйгээр алт олборлож Газрын тухай хуулийг зөрчиж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны “Газрын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг хангуулах тухай” 77 дугаар тогтоолыг буруугаар ашиглаж, ашиг сонирхлын үүднээс дуудлага худалдаа явуулалгүй, төсөл сонгон шалгаруулалгүйгээр газар эзэмшүүлж газрын суурь үнэ авсан мэдээлэл байна.

Иргэдэд газрыг үнэгүй өмчлүүлэх хугацаа 2018 оны 5-р сард дуусах хүртэлх 1 жил хагас гаруйн хугацаанд 55.2 мянган иргэнд газрыг нь өмчлүүлэх шаардлагатай байгаа, Улаанбаатар хотын иргэд манай аймгийн зарим сумдад газар өмчилж авах нь эрчимжсэнтэй уялдуулан газар өмчилж авахын ач холбогдлыг тодорхой баримт, бодит жишээтэйгээр иргэдэд сайтар сурталчилж, газар өмчлөх хүсэлтийг нь гаргуулж шийдвэрлэх ажлыг үр дүнтэй арга хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Төв аймгийн газар зохион байгуулалтын талаар 2016 онд хийх ажлын чиглэл”-ийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, иргэдэд газар өмчлүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллах шаардлагатай байгааг тэмдэглээд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын “з”, 19.1, 20.1, “Газрын тухай” хуулийн 20 дугаар зүйлйн 20.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Газрын тухай”, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар дараах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Ж. Батжаргал/-д даалгасугай.

1.1 “Аймгийн Газар зохион байгуулалтын талаар 2016 онд хийх ажлын чиглэл”-ийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ нэг бүрийн биелэлтийн явцыг сумдад шалган танилцаж, хяналт үнэлгээ хийж, дүгнэлт өгч шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах

1.2 Газар өмчилж аваагүй байгаа аймгийн харьяат 50 гаруй мянган иргэнийг Монгол Улсын иргэнд нэг удаа үнэ төлбөргүй газар өмчлүүлэх хуулийн хугацаа дуусах 2018 оны 05 дугаар сарын 01-ний дотор өмчийн газартай болгох бодлого, авах арга хэмжээ, хэрэгжүүлэх арга замыг оновчтойгоор тодорхойлж аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусган хэрэгжилтийг хангуулах

1.3 Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс болон Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдын холбогдох ажилтнуудыг оролцуулсан ажлын хэсэг томилж, иргэнд газар өмчлүүлэх ажлын талаар сургалт сурталчилгааг эрчимтэй хийх, газар өмчлөөгүй иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, сумын төв, бусад суурин газрын бүх өрхийн эзэмшиж буй хашааны газрыг энэ онд багтаан өмчлүүлэх, сумдын газраа өмчлөөгүй иргэн бүрт өмчлүүлэхэд шаардагдах газрын хэмжээг тодорхойлж, байршлыг тогтоон орон нутгийн хамгаалалтад авах, шаардлагатай тохиолдолд сумын төв, суурин газрын тэг гортигийг томсгох, өмнө тогтоосон нэг иргэнд өмчлүүлэх газрын хэмжээг хянан үзэх асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх

1.4 Аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай байгуулах “Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд” иргэнд газар өмчлүүлэх асуудлыг тодорхой тусгаж биелэлтийг дүгнэж ажиллах

1.5 Заамар болон бусад зарим сумдын нутагт газар эзэмших шийдвэргүйгээр ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд яаралтай шалгалт

хийж, газрын захирамжийг нөхөн гаргуулж, төлбөр ногдуулж хураан барагдуулах, буруутай этгээдэд хариуцлага тооцож арга хэмжээ авах


1.6 Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдын газрын даамлуудын ажлын хариуцлага, сахилгыг бэхжүүлэн, идэвх санаачлагыг өндөржүүлж, газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах талаар Газрын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн албан тушаалтан, газар эзэмших, ашиглах, өмчлөх талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллах

1.7 Сумдын газар зохион байгуулалтын 2016 оны төлөвлөгөөнд тусгагдсан газрыг өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулах ажлыг Газрын тухай хуулийн 33.1.2 дахь заалтын дагуу хийлгэж, сумдад зохион байгуулж байгаа газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай танилцаж мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, уг ажлыг хууль тогтоомжийн дагуу шударга, ил тод явуулж хэвшүүлэх

1.8 Аймаг, сумдын Засаг дарга нарын 2013-2016 онд газрын асуудлаар гаргасан “Газрын тухай”, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх” тухай хуулиудын холбогдох заалтыг зөрчиж газар эзэмшүүлсэн, өмчлүүлсэн, ашиглуулсан энэ тогтоолын хавсралтад дурдсан захирамжуудыг нягтлан үзэж Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийг үндэслэн хүчингүй болгуулах, шаардлагатай нөхцөлд өөрийн бүрэн эрхийнхээ дагуу хүчингүй болгох арга хэмжээ авах.

2. “Газрын тухай”, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх” тухай болон холбогдох бусад хулийн хэрэгжилтийн байдалд хяналт үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй.

3. Энэ тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Д.Батбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЭНХБАТ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2016 оны 12 сарын 22-ны
өдрийн 20 дугаар тогтоолын хавсралт

НЭГ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2013-2016 ОНД ХУУЛЬ ТОГТООМЖ
ЗӨРЧИН ИРГЭН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ГАЗАР ОЛГОСОН
ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН ШИЙДВЭРҮҮД

Д/Д	Огноо	Дугаар	Утга	Тайлбар
1	2014	A/456	Газар эзэмшүүлэх тухай	
2	2014	A/548	Газар эзэмшүүлэх тухай	
3	2014	A/593	Газар эзэмшүүлэх тухай	
4	2014	A/604	Гэр бүлийн хэрэгцээнд газар эзэмшүүлэх тухай	
5	2014	A/643	Газар эзэмшүүлэх тухай	
6	2014	A/648	Газар ашиглуулах тухай	
7	2014	A/649	Газар эзэмшүүлэх тухай	
8	2014	A/651	Газар эзэмшүүлэх тухай	
9	2015	A/77	Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай	Хууль зөрчиж олгосон газрын эрх шилжүүлсэн
10	2015	A/111	Газар эзэмшүүлэх тухай	
11	2015	A/267	Газар эзэмшүүлэх тухай	
12	2015	A/311	Газар эзэмшүүлэх тухай	
13	2015	A/369	Газар эзэмшүүлэх тухай	
14	2015	A/380	Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай	A/311 тоот захирамжаар хууль зөрчиж олгосныг шилжүүлсэн.
15	2016.02.02	A/42	Г.Сэрээжавт газар өмчлүүлэх тухай	
16	2016.02.02	A/137	Өмчилсөн газрын байршил өөрчлөх тухай	
17	2016.02.08	A/60	Газар өмчлүүлэх тухай	
18	2016.02.16	A/64	Газар өмчлүүлэх тухай	
19	2016.02.16	A/169	Газрын хэмжээг өөрчлөх тухай	Спорт цогцолборын зориулалтаар олгосон талбайгаас иргэдэд олгохоор 12319 метр квадрат талбайг хасч хэмжээг өөрчилсөн
20	2016.03.28	A/140	Газар өмчлүүлэх тухай	
21	2016.04.27	A/214	Газрын зориулалт өөрчлөх тухай	
22	2016.04.28	A/219	Газар өмчлүүлэх тухай	Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт
23	2016.05.02	A/229	Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай	
24	2016.05.03	A/235	Газар ашиглуулах тухай	
25	2016.05.03	A/235	Газар эзэмшүүлэх тухай	

26	2016.05.04	A/293	Газар эзэмшүүлэх тухай	
27	2016.05.09	A/248	Газар өмчлүүлэх тухай	
28	2016.05.09	A/252	Газар эзэмшүүлэх тухай	
29	2016.05.12	A/262	Газар өмчлүүлэх тухай	
30	2016.05.20	A/297	Д.Амартүвшинд газар өмчлүүлэх тухай	
31	2016.05.23	A/281	Өмчилсөн газрын байршил өөрчлөх тухай	Хашааны газраа сунгаж барьсан 4 иргэнд суурь үнэ төлүүлж, өмчлүүлэх шийдвэр гаргасан
32	2016.05.24	A/282	Д.Оюунбаярт газар өмчлүүлэх тухай	
33	2016.05.26	A/290	Г.Ариунбаатарт газар өмчлүүлэх тухай	
34	2016.05.30	A/292	Газар эзэмшүүлэх тухай	
35	2016.05.30	A/294	Д.Атарцэцэгт газар өмчлүүлэх тухай	
36	2016.05.30	A/295	Б.Батзоригт газар өмчлүүлэх тухай	
37	2016.06.06	A/308	Эрх шилжүүлэх тухай	
38	2016.06.09	A/314	Д.Ононд газар өмчлүүлэх тухай	
39	2016.06.09	A/315	Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай	
40	2016.06.09	A/316	Р.Эрдэнэцэцэгт газар эзэмшүүлэх тухай	
41	2016.06.10	A/328	Газар эзэмшүүлэх тухай	
42	2016.06.10	A/329	Газар өмчлүүлэх тухай	
43	2016.06.10	A/330	Газар өмчлүүлэх тухай	“Ач холдинг” ХХК-ийн дуудлага худалдаагаар эзэмшиж буй газраас хасаж өмчлүүлсэн. ГЗБ-ын төлөвлөгөөнд тусгагдаагүй.
44	2016.06.30	A/357	Газар ашиглуулах тухай	
45	2016.07.01	A/362	Газар эзэмшүүлэх, газар эзэмшүүлэх эрх шилжүүлэх тухай	
46	2016.07.04	A/385	Өмчилсөн газрын байршил өөрчлөх тухай	
47	2016.07.04	A/386		Сэргэлэн сумын нутаг дэвсгэр, ГЗБ-ын төлөвлөгөөнд тусгагдаагүй.
48	2016.07.05	A/391	Х.Болормаад газар өмчлүүлэх тухай	
49	2016.07.05	A/392	Д.Намбарт газар өмчлүүлэх тухай	
50	2016.07.05	A/393	Газар эзэмшүүлэх тухай	
51	2016.07.05	A/394	Л.Даваасүрэнд газар өмчлүүлэх тухай	
52	2016.07.05	A/395	Т.Мөнхсүлдэд газар өмчлүүлэх тухай	
53	2016.07.05	A/397	Д.Баярцэцэгт газар өмчлүүлэх	

			тухай	
54	2016.07.06	A/403	Газрын хэмжээг өөрчлөн газар өмчлүүлэх тухай	
55	2016.07.07	A/415	Газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай	
56	2016.07.08	A/417	Газар өмчлүүлэх тухай	3 өргөдөлтэй, бусад нь анхны материал байхгүй
57	2016.07.18	A/425	Газар эзэмшүүлэх тухай	
58	2016.07.19	A/427	Эрх шилжүүлэх тухай	
59	2016.07.19	A/439	Эрх шилжүүлэх тухай	Сэргэлэн сумын нутаг дэвсгэр
60	2016.07.19	A/440	Газар өмчлүүлэх тухай	
61	2016.07.19	A/441	Газар өмчлүүлэх тухай	
62	2016.07.19	A/446	Газар эзэмшүүлэх тухай	
63	2016.07.20	A/447	Газар эзэмшүүлэх тухай	
64	2016.07.29	A/437	Өмчилсөн газрын байршил өөрчлөх тухай	385 дугаар захирамжтай 7 иргэний нэр давхардсан, 2 иргэн нэмсэн

___ooOoo___

ХОЁР.СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2013-2016 ОНД ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИН ИРГЭН
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ГАЗАР ОЛГОСОН ШИЙДВЭРҮҮД

Д/Д	Сум	Огноо	Дугаар	Утга	Тайлбар
	Алтанбулаг	2013	Б/55	Газар эзэмшүүлэх тухай	
	Алтанбулаг	2013	Б/56	Газар эзэмшүүлэх тухай	
	Алтанбулаг	2014	Б/56	Газар эзэмшүүлэх тухай	
	Баян	2015			“Баян саминтал” ХХК-д бэлчээр хашиж хамгаалах, тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 500 га газрыг олгосон боловч тухайн аж ахуйн нэгж зориулалтын дагуу ашиглалгүй, Газрын тухай хуулийн 40.1.2, 40.1.4 дэх заалтыг зөрчсөн.
	Баянчандмань	2016	A/73	Газар эзэмшүүлэх тухай	
	Баянчандмань	2016	A/117	Газар эзэмшүүлэх тухай	
	Баянчандмань	2016	A/128	Газар эзэмшүүлэх тухай	
	Баянчандмань	2016	A/205	Газар эзэмшүүлэх тухай	
	Сэргэлэн	2014	272	Газар эзэмшүүлэх тухай	
	Сэргэлэн	2014	293	Газар эзэмшүүлэх тухай	
	Сэргэлэн	2014	315	Газар эзэмшүүлэх тухай	
	Сэргэлэн	2015	A/314	Газар эзэмшүүлэх тухай	
	Сэргэлэн	2016	A/13	Газар эзэмшүүлэх тухай	
	Сэргэлэн	2016	A/273	Газар эзэмшүүлэх тухай	
	Сэргэлэн	2016	A/41	Газар эзэмшүүлэх тухай	
	Сэргэлэн	2016	A/41	Газар эзэмшүүлэх тухай	
	Сэргэлэн	2016		Газар эзэмшүүлэх тухай	“Хар гүнж” ХХК-д Баянгийн аманд 25 га газрыг мод үржүүлэг, аялал жуулчлалын зориулалтаар олгосон нь ГТХ-ийн 33.1.2-ийг зөрчсөн
	Зуунмод	2013	A/140	Газрын хэмжээг өөрчлөх тухай	
	Зуунмод	2014	A/115	Газар эзэмшүүлэх тухай	
	Зуунмод	2016	A/15	Газар эзэмшүүлэх тухай	
	Зуунмод	2016	A/141	Газар эзэмшүүлэх тухай	
	Зуунмод	2016	A/143	Газар эзэмшүүлэх тухай	
	Зуунмод	2016	A/133	Газар ашиглуулах тухай	
	Зуунмод	2016	A/151	Газар эзэмшүүлэх тухай	